

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ТОГТООЛ**

2022 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 22/01/03 Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.3 дахь заалт, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж, Делта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 8-р сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
  1. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
  2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах
  3. Өрийг хувьцаагаар солих
  4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
  5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
  6. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2022 оны 7 дугаар сарын 25-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2022 оны 8-р сарын 11-нд уг зарыг давтан, 2022 оны 7-р сарын 30-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн 09:00 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.

7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2022 оны 8-р сарын 03 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Г.Халиунаа/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Г.Халиунааг, гишүүнээр Р.Отгонбат, Тооллогын комиссийн даргаар Х.Мөнгөнцэцэг, гишүүнээр О.Мэндбаяр нарыг тус тус томилсугай.
10. "Евразиа капитал холдинг ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАЛИУНАА